



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 121

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хархорум музейн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй, 12 нэрийн, нийт 14,832,700.00 (арван дөрвөн сая найман зуун гучин хоёр мянга долоон зуу) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Даваажаргал, Хархорум музейн захирал Т.Баяраа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Акталж данснаас хасах хөрөнгийг сэлбэгээр ашиглах, устгах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132000369

6-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

ХАРХОРУМ МУЗЕЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг
МАШИН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ							
1	Плитка K-7025	12/10/2017	ш	1	85,000	85,000.00	0.00
2	Зөөврийн компьютер /Acer 2017/	12/10/2017	ш	2	756,900	1,513,800.00	0.00
3	Дэлгэц /Dell/	12/18/2018	ш	4	299,900	1,199,600.00	0.00
4	Дэлгэц /Dell 21,5/	12/18/2018	ш	1	459,900	459,900.00	0.00
5	Хөлдөөгч	12/10/2017	ш	1	450,000	450,000.00	0.00
6	Ус буцалгагч	12/10/2017	ш	1	110,000	110,000.00	0.00
7	Процессор /Dell i5/	12/18/2018	ш	3	1,739,900	5,219,700.00	0.00
8	Процессор /Dell i3/	12/18/2018	ш	3	1,219,900	3,659,700.00	0.00
9	Американо кофе чанагч	12/19/2017	ш	1	700,000	700,000.00	0.00
10	Мөс бутлагч	12/10/2017	ш	1	600,000	600,000.00	0.00
11	Халуун үзэгч, гар ариутгагч	12/27/2020	ш	1	185,000	185,000.00	0.00
12	Tab A	12/20/2018	ш	1	650,000	650,000.00	0.00
	Нийт дүн			20		14,832,700.00 (арван дөрвөн сая найман зуун гучин хоёр мянга долоон зуу)	0.00